

Сангийн сайдын 2023 оны 12
дугаар сарын 26-ний өдрийн 267
тоот тушаалын хавсралт

ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТӨСӨВТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ, ТӨСВИЙН ЭРСДЭЛ ТООЦОХ ЗАГВАР

Нэг.Зорилго

1.1. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн төсвийн зардал, эрсдэлийг үнэлэх, түүнийг удирдах болон түншлэлийн төслийн төсөвт үзүүлэх нөлөөлөл, төсвийн эрсдэл тооцож, тухайн төслийг түншлэлээр хэрэгжүүлэх эсэхэд шийдвэр гаргахад энэхүү загвар /цаашид "Загвар" гэх /-ын зорилго оршино.

1.2. Энэ журмын 1.1-д заасан загварыг олон улсад ашиглагддаг программ болох "PERAM:2.0" гэж нэрлэх бөгөөд энэ журам болон холбогдох гарын авлагын дагуу ашиглана.

1.3. Загварыг Microsoft excel программ дээр ашиглах бөгөөд программын хэл нь англи хэл дээр байна.

1.4. Түншлэлийн төслийн төсвийн эрсдэлийн үнэлгээг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 5.1.25-д зааснаар ойлгоно.

1.5. Загвараар түншлэлийн төслийн төсвийн зардал, эрсдэл, төсөвт үзүүлэх нөлөөлөл, төсвийн эрсдэлийг тооцож, үнэлэхдээ түншлэлийн төслийн бүрэн шинжилгээ, тухайн төслийн бусад мэдээлэлд үндэслэнэ.

Хоёр.Загварын хамрах хүрээ, үе шат болон тооцооллын суурь

2.1. Загварыг түншлэлийн бие даасан төслийн хувьд тухайн төслийн төсвийн зардал, эрсдэл нөлөөллийг тооцохоос гадна түншлэлийн бүх төсөл эсвэл бүлэг төслүүдээс төсөвт үзүүлж болох нөлөөлөл, төсвийн эрсдэл зэргийг тооцоход ашиглана:

2.1.1. түншлэлийн бие даасан төслийн төсвийн зардлын тооцоолол, төсөвт үзүүлэх нөлөөллийг дараах байдлаар гаргана. Үүнд:

2.1.1.1. улсын санхүүгийн тайланд үзүүлэх нөлөө;

2.1.1.2. төсвийн тэнцэлд үзүүлэх нөлөө;

2.1.1.3. төсвийн мөнгөн гүйлгээнд үзүүлэх нөлөө;

2.1.2. түншлэлийн багц буюу хэд хэдэн төсвийн зардлын тооцоолол, төсөвт үзүүлэх нөлөөллийг дараах байдлаар гаргана. Үүнд:

2.1.2.1. төслүүдийг багцыг солих, өөрчлөх болон дэд багц болгох

2.1.2.2. түншлэлийг багц төслийн төсөвт үзүүлэх нөлөөллийг тооцохдоо төсөл бүрийн төсвийн хувьсагчдын нийлбэрийг тооцоолох замаар тооцно.

2.2. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслүүдийн төсвийн зардал, эрсдэлийг болон төсөвт үзүүлэх нөлөөллийг тооцоход дараах үе шаттайгаар энэхүү загварыг ашиглана. Үүнд:

2.2.1. төслийг түншлэлээр хэрэгжүүлэх эсэх шийдвэр гаргах эхний үе шатанд;

2.2.2. түншлэлийн гэрээ байгуулсан төслүүдийн хэрэгжилтийн үе шатанд;

2.2.3. түншлэлийн төслийг хэрэгжиж дуусах үе шатанд.

2.3. Загварын тооцоолол нь нягтлан бодох бүртгэлийн аккредитаци ба мөнгөн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн суурь байна.

2.4. Загвар нь түншлэлийн төсөл бүрийн жилийн орлого, зардал, түүний дотоод өгөөжийн түвшин, төслийн холбогдох хөрөнгө, өр төлбөрийн үнэ цэнийг төслийн бүх мөчлөгөөр тооцоолно.

2.5. Загвар нь түншлэлийн төслөөс үүсэх гол эрсдэл, түүний магадлал, нөлөөлөл, түүнчлэн бууруулах арга хэмжээг тодорхойлохоос гадна түншлэлийн төслийн гэрээг цуцлах тохиолдолд гарч болзошгүй төсвийн зардал, эрсдэлийг мөн тодорхойлно.

2.6. Загвар нь түншлэлийн төслийн эрсдэлийг үнэлгээгээр хэрэглэгчдэд үүсэх эрсдэл, түүнийг түншлэлийн гэрээнд хэрхэн хуваарилсан, түүнчлэн тэдгээрийн магадлал, төсөвт үзүүлэх нөлөөллийг мөн тооцно.

2.7. Загвараар түншлэлийн төслийн төсөвт үзүүлэх нөлөөлөл, төсвийн эрсдэлийг тооцохоос гадна хувийн хэвшлийн түншлэгчийн санхүүгийн тайланд түншлэлийн төслөөс үзүүлэх нөлөөллийг тооцож болно.

Гурав.Түншлэлийн төслийн төсвийн эрсдэлийг тогтоох, түүнийг үнэлэх

3.1. Загвар нь дараах байдлаар түншлэлийн төсөлд гарч болох төсөв, санхүүгийн гол эрсдэлийг тодорхойлно:

Эрсдэлийн матриц

ЭРСДЭЛИЙН ГОЛ АНГИЛАЛ		ЭРСДЭЛИЙН ДЭД АНГИЛАЛЫН ТОО
1	Засаглалын эрсдэл	3 нарийвчилсан эрсдэл
2	Бүтээн байгуулалтын эрсдэл	19 нарийвчилсан эрсдэл
3	Эрэлтийн эрсдэл	10 нарийвчилсан эрсдэл
4	Үйл ажиллагаа, гүйцэтгэлийн эрсдэл	7 нарийвчилсан эрсдэл
5	Санхүүгийн эрсдэл	4 нарийвчилсан эрсдэл
6	Давагдашгүй хүчин зүйлийн эрсдэл	Дэд ангилал байхгүй
7	Төрийн бодит сөрөг үйл ажиллагаа	Дэд ангилал байхгүй
8	Хуулийн өөрчлөлт	Дэд ангилал байхгүй
9	Санхүүгийн тэнцвэрт байдлыг дахин тэнцвэржүүлэх	3 нарийвчилсан эрсдэл
10	Дахин хэлэлцэх эрсдэл	Дэд ангилал байхгүй
11	Гэрээ цуцлах эрсдэл	2 нарийвчилсан эрсдэл

3.2. Эрсдэлийн матрицаар түншлэлийн төслийн эрсдэлийг тодорхойлсны дараа загвараар дараах зүйлсийг үнэлнэ:

3.2.1. Магадлалыг тодорхойлох: Магадлалыг “бага”, “дунд”, “өндөр” гэж тодорхойлно.

Хэмжүүр	Магадлал
Бага	- Магадлал тун бага - Маш онцгой нөхцөл байдлыг шаардана
Дунд	- Боломжтой - Урьд нь тохиолдож байсан

Өндөр	- Магадлал өндөр, бараг тодорхой - Өмнө нь тохиолдож байсан
-------	--

3.2.2. Төсөвт үзүүлэх нөлөө: Загвар нь эрсдэлийн матрицаар гарсан эрсдэлүүдийн төсөвт үзүүлэх нөлөөллийг тухайн түншлэлийн төслөөс улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл, үр дагаврыг тодорхойлно.

3.3. Загвараар түншлэлийн төслийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ буюу эрсдэлийн зэрэглэлийг тооцоолохын тулд “магадлал” болон “төсвийн нөлөө”-г хослуулан тооцоолно:

3.3.1. өндөр магадлалтай, төсөвт үзүүлэх нөлөө өндөр гэж үнэлсэн эрсдэлийн зэргийг “ноцтой” гэж;

3.3.2. өндөр /дунд/ магадлалтай, төсөвт үзүүлэх нөлөө дунд /өндөр/ гэж үнэлсэн эрсдэлийн зэргийг “өндөр” гэж;

3.3.3. дунд магадлалтай, төсөвт үзүүлэх нөлөө нь дунд гэж үнэлсэн эсвэл бага магадлалтай, төсөвт үзүүлэх нөлөө нь өндөр, мөн өндөр магадлалтай, төсөвт үзүүлэх нөлөө нь бага эрсдэлийн зэргийг “дунд” гэж;

3.3.4. дунд магадлалтай, төсөвт үзүүлэх нөлөө нь бага эсвэл бага магадлалтай, төсөвт үзүүлэх нөлөө нь дунд эрсдэлийн зэргийг “бага” гэж;

3.3.5. бага магадлалтай, төсөвт үзүүлэх нөлөө нь бага эрсдэлийн зэргийг “хамааралгүй” гэж тус тус тодорхойлно.

Эрсдэлийн зэрэглэл = Магадлал * төсөвт үзүүлэх нөлөө				
Төсвийн нөлөө	Өндөр	Дунд	Өндөр	Маш чухал
	Дунд	Бага	Дунд	Өндөр
	Бага	Хамааралгүй	Бага	Дунд
		Бага	Дунд	Өндөр
		Магадлал		

3.4. Түншлэлийн төслийн төсвийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг тодорхойлохдоо загвараар тодорхойлсон эрсдэл бүрд хамаарах эрсдэлийг бууруулах арга хэмжээ байгаа эсэхийг үнэлэх асуулт тавьж, түүний дагуу эрсдэлийг бууруулах арга хэмжээг тодорхойлно.

Авах арга хэмжээ = Эрсдэлийн зэрэглэл * бууруулах арга хэмжээ						
Бууруулах арга хэмжээ	Үгүй	Арга хэмжээ авах шаардлагагүй	Дунд зэргийн ач холбогдолтой	Өндөр ач холбогдолтой	Өндөр ач холбогдолтой	Маш чухал
	Тийм	Арга хэмжээ авах шаардлагагүй	Бага ач холбогдолтой	Дунд зэргийн ач холбогдолтой	Дунд зэргийн ач холбогдолтой	Өндөр ач холбогдолтой
		Хамааралгүй	Бага	Дунд	Өндөр	Ноцтой
		Эрсдэлийн зэрэглэл				

3.5. Эрсдэлийг бууруулах арга хэмжээг түншлэлийн төслийн үе шатаас хамааран дараах байдлаар тодорхойлно:

3.5.1. төслийн загвар, бүтцийг өөрчлөх; /энэ нь зөвхөн түншлэлийн гэрээ байгуулахаас өмнөх үе шатанд хамаарна/

3.5.2. нөлөөллийг бууруулах нэмэлт арга хэмжээ хэрэгжүүлэх;

3.5.3. эрсдэл бодитой болсон тохиолдолд төсвөөс болзошгүй зардлыг санхүүжүүлэх эсэх.

3.6. Загвар нь түншлэлийн төслийн төсвийн эрсдэлийн матрицыг үүсгэх бөгөөд дараах байдлаар тодорхойлох жишээ:

Эрсдэлийн тодорхойлолт	Магадлал	Төсвийн нөлөө	Эрсдэлийн зэрэг Магадлал*Нөлөө	Эрсдэл бууруулах стратеги хэрэгжүүлсэн үү?	Тэргүүлэх үйл ажиллагаа	Санал болгож буй эрсдэл бууруулах стратеги
Засаглалын эрсдэл	Бага	Дунд	Бага	Үгүй	Дунд зэргийн ач холбогдол	
Бүтээн байгуулалтын эрсдэл	Дунд	Өндөр	Өндөр	Тийм	Дунд зэргийн ач холбогдол	
Эрэлтийн эрсдэл	Дунд	Бага	Бага	Үгүй	Дунд зэргийн ач холбогдол	
Үйл ажиллагаа, гүйцэтгэлийн эрсдэл	Бага	Бага	Хамааралгүй	Тийм	Арга хэмжээ авахгүй	
Санхүүгийн эрсдэл	Дунд	Дунд	Дунд	Үгүй	Өндөр ач холбогдол	
Давагдашгүй хүчин зүйл	Бага	Бага	Хамааралгүй	Тийм	Арга хэмжээ авахгүй	
Төрийн бодит сөрөг үйл ажиллагаа	Дунд	Дунд	Дунд	Үгүй	Өндөр ач холбогдол	
Хуулийн өөрчлөлт	Дунд	Өндөр	Өндөр	Үгүй	Маш чухал	
Санхүүгийн тэнцвэрт байдлыг дахин тэнцвэржүүлэх	Өндөр	Дунд	Өндөр	Тийм	Өндөр ач холбогдол	
Дахин хэлэлцэх	Өндөр	Бага	Дунд	Тийм	Дунд зэргийн ач холбогдол	
Гэрээ цуцлах	Дунд	Дунд	Дунд	Тийм	Дунд зэргийн ач холбогдол	